

ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

/ Хорих байгууллагын албан хаагчдад хоригдолтой
ажилласны нэмэгдэл олгох журам /

2002 оны 10 дугаар сарын 23-ны өдөр

Дугаар 217

Улаанбаатар хот

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 137.2-т заасныг үндэслэн *Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь* :

1. “Хорих байгууллагын албан хаагчдад хоригдолтой ажилласны нэмэгдэл олгох журам”-ыг хавсралт ёсоор баталж, 2003 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

2. Хорих байгууллагын албан хаагчдад олгох хоригдолтой ажилласны нэмэгдлийн хэмжээг нэмэгдүүлсэнтэй холбогдон гарах зардлыг тухайн жилийн цалингийн сандаа багтаан зохицуулахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдоржид зөвшөөрсүгэй.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Заавар батлах тухай” Засгийн газрын 1994 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 145 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд Н.ЭНХБАЯР

Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.НЯМДОРЖ

**ХОРИХ БАЙГУУЛЛАГЫН АЛБАН ХААГЧИД ХОРИГДОЛТОЙ
АЖИЛЛАСНЫ НЭМЭГДЭЛ ОЛГОХ ЖУРАМ**

1. Хорих байгууллагын албан хаагчид хоригдолтой ажилласны нэмэгдэл тогтоож олгоход энэ журмыг мөрдөнө.

2. Хорих байгууллагад ажиллаж байгаа офицер, ахлагч, Тогтоол гүйцэтгэх газрын мөрдөн хөөх, эрэн сурвалжлах албаны ажилтанд хоригдолтой ажилласны нэмэгдлийг тухайн албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингаас дор дурдсан хувиар бодож олгоно:

№	Хорих ангийн дэглэмийн төрөл	Хоригдолтой ажилласны нэмэгдлийн хэмжээ (хувиар)
	Жирийн дэглэмтэй хорих ангид	6
	Чанга дэглэмтэй хорих ангид	7
	Нэгдсэн эмнэлэг болон сүрьеэгийн хорих ангид	8
	Онцгой дэглэмтэй хорих ангид	8
	Гянданд	9
	Мөрдөн хөөх, эрэн сурвалжлах	9

3. Хоригдолтой ажилласны нэмэгдлийг тухайн байгууллагын даргын тушаалаар зөвхөн дээр дурдсан анги, салбарт ажиллаж байх хугацаанд олгоно. Албан хаагч өөр дэглэмтэй хорих ангид шилжин ажиллах тохиолдолд түүнд шилжин очсон хорих ангийн дэглэмийн төрөлд хамаарах нэмэгдлийг бодож олгоно. Ингэхдээ нэмэгдлийн зөрүүг тооцохгүй.

4. Хорих байгууллагын албан хаагч хоригдол оргуулсан, хоригдолтой ажиллах үүргээ биелүүлээгүй зэргээр ажлын хариуцлага алдаж, зөрчил гаргасан тохиолдолд байгууллагын даргын тушаалаар түүний хоригдолтой ажилласны нэмэгдлийг хасч болно.

5. Хорих байгууллагын албан хаагчид хоригдолтой ажилласны нэмэгдлийг тухайн байгууллагын төсвөөс олгоно.

-----oOo-----